



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 4/78

Улаанбаатар хот

Г Автомашингүй өдөр арга хэмжээний үеэр
мөрдөх нийтийн тээврийн үйлчилгээний
төлөвлөлтийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2018 оны A/861 дүгээр захирамж, 2016 оны A/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2018 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдах “Автомашингүй өдөр” арга хэмжээний үеэр 07:00 цагаас 17:00 цагийн хооронд Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Сөүлийн гудамж, Бээжингийн гудамж, Анкарагийн гудамж, Сүхбаатарын гудамж, Их сургуулийн гудамж, Самбуугийн гудамж, Элчингийн гудамж, Хөх тэнгэрийн гудамж, Партизаны гудамж, Төмөрчний гудамж, Гэндэнгийн гудамж, Олимпын гудамж, Чоймболын гудамжны авто замын хөдөлгөөнүүд хязгаарлагдахтай холбоотойгоор дээрх гудамж замаар үйлчилдэг нийтийн тээврийн чиглэлүүдийн замналын өөрчлөлтийн нэгдсэн зураглалыг нэгдүгээр, нийтийн тээрийн үйлчилгээний чиглэлүүдийг тухайн хугацаанд түр замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллах Автотээврийн хяналтын улсын байцаагч нарын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2018 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн төлөвлөлтийг боловсруулахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад чиглэлүүдийн өөрчлөлтийн талаар мэдээллийг өгч, үйлчилгээг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэболд/-т, чиглэлүүдийн үйлчилгээг өөрчлөгдсөн замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /З.Цэвээндорж/-т, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулж, тухайн өдөр ажилласан албан хаагчдыг нөхөж амраахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /М.Мөнхбаяр/-т, тухайн өдөр ажиллах нийтийн тээврийн хэрэгслийг төлөвлөлтийн дагуу үйлчилгээнд ажиллуулсан

Монголия
Ганасан М.Монголийн
Боловсруулж Бонцгүйн
... хүн бичсэн
С.Сардамаа
СМГСС

Эсэхийг нягталж, ажлын гүйцэтгэлийг Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системээр нэгтгэн гаргахыг Улаанбаатар смарт карт ХХК /Шин Дун Y/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

